

Бататгах дасгалууд

Тохирох үгийг зөөж байрлуулна уу.

1. Зүрхний агшилт нь тасалгааны доторх даралтыг _____ бол амрах нь даралтыг _____

ихэсгэдэг

бууруулдаг

2. Зүрх судасны тогтолцоонд цусыг хөдөлгөх гол хүч болох нь _____ юм.

Даралтын зөрүү

AV хавхлагууд

Пейсмейкер

3. Зүрх хэмнэлт мөчлөгөөр агшиж сулардаг бөгөөд _____ үедээ цусыг шахаж, _____ үед тасалгаанууд нь цусаар дүүрнэ.

агших

сулрах

4. Мөчлөгийн агшилтын үеийг _____, сулралтын үеийг _____ гэнэ.

систол

диастол

5. Зүрхний баруун тосгуурын дээд хэсэгт бүлэг, тусгай зүрхний булчингийн эсүүд байх ба түүнийг _____ буюу синусын зангилаа гэнэ.

Даралтын зөрүү

AV хавхлагууд

Пейсмейкер

6. Дараах зурагт ховдлын даралт _____ уушги, аортын даралт _____ байгаа учир энэ тохиолдолд тал саран хавхлагууд _____


бага

ижил

их

Нээгдэнэ

хаагдана



7. Тосгуурын даралт ховдлын даралтаас их байвал AV хавхлагууд нээгдэж даралтын градиент урвуу үед хаагдана. Тэгвэл дараах зурагт тохирох тайлбарыг байрлуулна уу.

А:

Тосгуурын даралт их

Ховдлын даралт их



Тосгуурын даралт бага

Ховдлын даралт бага


Б:

Тосгуураас ховдол руу цус шилжинэ

Ховдлоос тосгуур руу цус шилжинэ



8. Зүрхний мөчлөгийн үе шатуудыг дүрсэлсэн дараах графикт ховдлын агшилтаар нээгдэх хагас-саран хавхлага (ХСХ) болон зүрхний тасалгаануудын хооронд орших тосгуур-ховдлын хавхлага (ТХХ)-ын нээгдэх, хаагдах үйл явцыг тэмдэглэв. Зургийг сайтар ажиглаад зүрхний мөчлөгийн үе шатуудаас ховдлын сулралын үе (ховдлын диастол)-ыг тэмдэглэсэн үсгийг байрлуулна уу.



A

B

C

D